

3.2 Багшийн мэдээлэл засварлах

Багшийн мэдээлэл засах үйл явцын зааварчилгаа

Багшийн мэдээлэл засварлах үйлдлийг хийхээс өмнө системд дараах үйлдлийг хийсэн байх ёстой.

- Боловсролын удирдлага системд багш нэмэх үйлдлээр багшийг бүртгэсэн байх
- Багшийн заадаг бүх хичээлийг Хичээл хэсэгт үүсгэж, хичээлийг Хөтөлбөр, төлөвлөгөөнд нэмсэн байх
- Анги бүлэг хэсэгт бүлэг үүсгэхдээ хариуцсан багшийг (АУБ) тодорхойлсон байх
- Сургалтын орчин хэсэгт хичээлийн байр болон байранд харьяалагдах анги, танхимыг үүсгэсэн байх

Багшийн мэдээлэл оруулах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. БУ системийн Багш үйл ажиллагааг сонгоно.
2. Багшийн жагсаалтаас мэдээлэл оруулах багшийн нэрийг сонгоно.
3. Үйлдэл цэсээс **багшийн мэдээлэл** үйлдлийг дарна эсвэл жагсаалтаас багшийн нэр дээр дарна.
4. Багштай холбоотой бүлэг мэдээллийг оруулаад хадгална.

Багшийн мэдээлэл оруулах үйлдлийг хийх алхамчилсан дараалал дараах байдалтай байна.

Үйл ажиллагааны жагсаалтаас **Багш**-ийг сонгоход дараах цонх нээгдэнэ.

№	Ажилтны нэр	Төрөл	Албан тушаал	Төлөв
1	M Brittany Leigh	Ахлах ангийн үндсэн багш	Багш, англи хэлний	Идэвхтэй
2	E Christian Hans	Бага ангийн үндсэн багш	Багш, англи хэлний	Идэвхтэй
3	K David Andrew	Дүнд ангийн үндсэн багш	Багш, физикийн /ЕБС/	Идэвхтэй
4	F Karey Ann	Бага ангийн үндсэн багш	Багш, англи хэлний	Идэвхтэй
5	S Malta	Бага ангийн үндсэн багш	Багш, англи хэлний	Идэвхтэй
6	G Marilyn	Бага ангийн үндсэн багш	Багш, бага ангийн	Идэвхтэй
7	P Paul Christian	Бага ангийн үндсэн багш	Багш, англи хэлний	Идэвхтэй
8	K Tom Alikane	Бага ангийн үндсэн багш	Багш, бага ангийн /мэргэжлийн/	Идэвхтэй
9	D Amanda Fay	Ахлах ангийн үндсэн багш	Багш, биологийн /ЕБС/	Идэвхтэй
10	R Bruna	Бага ангийн үндсэн багш	Багш, англи хэлний	Идэвхтэй
11	F.Christopher Mark	Ахлах ангийн үндсэн багш	Багш, англи хэлний	Идэвхтэй
12	R.Desiree Elenys	Ахлах ангийн үндсэн багш	Багш, тусгай хэрэгцээт боловсролын /Тусгай/	Идэвхтэй
13	V.Francisco Javier	Ахлах ангийн үндсэн багш	Багш, англи хэлний	Идэвхтэй
14	E.Jacqueline Carol	Бага ангийн үндсэн багш	Багш, англи хэлний	Идэвхтэй
15	S.Jagienka Elzbieta	Бага ангийн үндсэн багш	Багш, англи хэлний	Идэвхтэй
16	H.Jordan Alexander	Бага ангийн үндсэн багш	Багш, математикийн	Идэвхтэй
17	K.Khalifa Abdul	Бага ангийн үндсэн багш	Багш, түүх-нийгэм судлалын /ЕБС/	Идэвхтэй

Цонхны баруун дээд хэсэгт байрлах үйлдэл цэсээс **Багшийн мэдээлэл** үйлдлийг дарах эсвэл **багшийн**

нэр дээр дарахад багшийн мэдээлэл харуулсан цонх нээгдсэний **мэдээлэл засах** товчийг дарахад дараах цонх дуудагдана.

БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА 119 ES3310

Багшийн мэдээлэл | З.А

ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ Болих Хадгалаад хаах

Үндсэн мэдээлэл

Нэр	А
Овог	З:
Регистрийн дугаар	дн
Албан тушаал	Багш, техник, технологийн
* Төрөл	Дунд ангийн үндсэн багш
* Салбар, бүрэлдэхүүн	сумын бүрэн дунд сургу:
САЗНэгж	Дунд Ангийн Заах Аргын Нэгд:
Удирдагч эсэх	<input type="checkbox"/>
* Төлөв	Идэвхтэй

Үндсэн мэдээлэл:

Овог

Багшийн үндсэн мэдээллээс автоматаар татагдана.
Засах боломжгүй байна.

Нэр

Багшийн үндсэн мэдээллээс автоматаар татагдана.
Засах боломжгүй байна.